



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 8/06

Арвайхээр сум

Газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг, Д.Пүрэвдорж-8 гудамж, 850 тоотод байрлах Жанчивын Самданжигмэдийн (ЙЮ60121697) эзэмшил гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай 1772м² газар, 13 дугаар баг, Төв цэнгэлдэх-3 гудамж, 311 тоотод байрлах Жанчивын Самданжигмэдийн (ЙЮ60121697) эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 677м² газрын зориулалтыг тус тус 9 ба түүнээс дээш давхар орон сууцны зориулалттай болгон өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

И.ДОРЖСҮРЭН



8224 11 0013

D:My Doc. Zahiramj. Zasag darga